



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/187

Арвайхээр


Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх
дадлага сургуулилтын бэлэн байдлыг
хангах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны “Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага сургуулилт зохион байгуулах тухай” 33 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.КОВИД-19 халдварт цартахлын хариу арга хэмжээний дадлага сургуулилтын бэлэн байдлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хариу арга хэмжээний удирдамжийг хоёрдугаар, байгууллагуудын чиг үүргийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дадлага сургуулилтын бэлэн байдлыг хангаж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100411

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 05-ны өдрийн 11/131 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАРТАХЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАДЛАГА,
СУРГУУЛИЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

- Сургуулийн удирдагч: Эрүүл мэндийн газрын дарга, Аймгийн онцгой комиссын гишүүн Д.Шивааннүрдэв
- Штабын дарга: Аймгийн Засаг даргын орлогч, Аймгийн онцгой комиссын гишүүн И.Доржсүрэн
Онцгой байдлын газрын дарга, Аймгийн онцгой комиссын гишүүн, Т.Мөнхдорж
- Штабын орлогч: Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа Б.Батбилэг
Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Оюунтуяа
- Чиглүүлэгч: -Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга Ю.Ичинноров
-Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга М.Золзаяа
-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Э.Хүдэрчулуун
- Гишүүд: -Арвайхээр сумын Засаг дарга О.Пүрэвдорж
-Цагдаагийн газрын дарга О.Ганбат
-Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Дуламсүрэн
-ЗХ-ний 256-р ангийн захирагч Б.Галбадрах
-Зооноз өвчин судлалын төвийн дарга Б.Сүхбаатар
-Өвөрхангай аймаг дахь Улаан Загалмайн хорооны дарга Б.Энхцогт
- Нарийн бичгийн дарга: -Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч Хошууч Н.Намхайнямбуу
-Эрүүл мэндийн газрын Яаралтай, Гамшгийн үеийн тусламж, ЦЦБ-ны аюулгүй байдал, эмнэлгээс шалтгаалах халдварын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Ганцэцэг

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 05-ны өдрийн 4/18 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАРТАХЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАДЛАГА, СУРГУУЛИЛТЫН УДИРДАМЖ

Сэдэв: “КОВИД-19” халдварт цартахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ

Зорилго: “КОВИД-19” халдварт цартахлаас урьдчилан сэргийлэх, цартахалтай тэмцэх хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, 3 түвшний удирдлагыг нягтруулах, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, онцгой нөхцөл байдлын үеийн хариу арга хэмжээний тактикийг боловсронгуй болгох, нэрвэгдэгсдийг эмчлэх, хорио цээр, халдвар хамгааллын дэглэм тогтоох чиглэлээр хээрийн хүн эмнэлэг дэлгэх бэлтгэл ажлыг хангах.

Зорилт:

1. Стратегийн, тактикийн, үйл ажиллагааны түвшний хүч хэрэгслийн хариу арга хэмжээ, мэдээллийн менежментийг нягтруулах
2. Цартахалтай тэмцэх томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг бодитоор тогтоох, санал боловсруулах
3. Онцгой нөхцөл байдлын үеийн /хүндэрсэн/ хариу арга хэмжээний тактикийг боловсронгуй болгох
4. Нэрвэгдэгсдэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах
5. Бүх төрлийн нөөцийн менежментийг хөгжүүлэх
6. “КОВИД-19”-т цартахлын халдварын үеийн төрийн болон төрийн бус байгууллага хоорондын харилцаа холбоо, оролцоог тодорхойлох

Хугацаа: 2020 оны 05 дугаар сарын 06,07,08-ны өдрүүдэд хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана.

Зохион байгуулах бүрэлдэхүүн: Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 05-ны өдрийн 41/05 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАРТАХЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ДАДЛАГА, СУРГУУЛИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тусгаарлах эмнэлгийг шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бэлтгэх
- Политехник коллежийн 200 ортой 1 дүгээр дотуур байрыг тусгаарлан ажиглах байраар бэлтгэж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бэлтгэх
- Томилгоот мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэх
- Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц, автомашин, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах

2. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА:

- Хээрийн эмнэлэг дэлгэх бэлтгэл ажлыг хангах
- Хээрийн эмнэлгийг зөөж тээвэрлэх, байршуулах, автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах
- Хөл хорионы дэглэм тогтоох үед ажиллах хөдөлгөөнт шалган нэвтрүүлэх байр, автомашин, тээврийн хэрэгслийг бэлтгэх

3. ЗЭВСЭГТ ХҮЧИН

- Хээрийн эмнэлэг дэлгэх бэлтгэл ажлыг хангах
- Хээрийн эмнэлгийг зөөж тээвэрлэх, байршуулах, автомашин техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах
- Хөл хорионы дэглэм тогтоох үед харуул хамгаалалт зохион байгуулах хүний нөөцийг бэлтгэх

4. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА

- Үзүүлэх сургууль, дадлага зохион байгуулах байршлыг хамгаалалтад авах хөдөлгөөнт болон суурин эргүүлийн байр, хяналтын камер, автомашин, тээврийн хэрэгсэл, хамгаалах тусгай хэрэгслийн бэлэн байдлыг хангах
- Хөл хорионы дэглэм тогтоох үед харуул хамгаалалт, техник хэрэгслийг бэлтгэх

5. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР:

- Хорио цээр, халдвар хамгааллын дэглэм сахиулахад шаардлагатай хэмжих, тандах багаж, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх
- Хөл хорионы дэглэм тогтоох үед үйлчлэх техник хэрэгсэл, хүний нөөцийг бэлтгэх

6. Бусад байгууллагаас шаардлагатай автомашин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн туслалцаа авна.